

Засгийн газрын 2025 оны ... дугаар  
сарын ... өдрийн ... дугаар тогтоолын 1  
дүгээр хавсралт

## **ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмаар паркийн үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэгийн хамрах хүрээ, дэмжлэгт тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, паркийн удирдлага, паркийн нэгжид дэмжлэг үзүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Татварын ерөнхий хууль, холбогдох татварын хууль тогтоомж болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3.Паркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 1.3.1.ил тод байх;
- 1.3.2.үр ашигтай байх;
- 1.3.3.хариуцлагатай байх;
- 1.3.4.хууль дээдлэх байх;
- 1.3.5.тэгш, шударга байх.

### **Хоёр.Паркийн дэмжлэгийн төрөл, хамрах хүрээ**

2.1.Дараах шаардлагыг хангасан паркад холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, санхүү төсвийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ:

2.1.1.паркийн удирдлага нь Засгийн газраас олгосон тусгай зөвшөөрөл авсан байх;

2.1.2.паркийн нэгж нь тусгай зөвшөөрөл бүхий паркийн удирдлагатай гэрээ байгуулсан байх;

2.1.3.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байх;

2.1.4.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан салбарт хамаарахгүй байх;

2.1.5.паркийн дэмжлэгийг паркийн нутаг дэвсгэрт авахаар байх;  
2.1.6.паркийн удирдлага нь паркийн нэгжүүдтэй байгуулсан гэрээний нэгдсэн бүртгэлийг хийж дэмжлэг авах этгээдийн жагсаалтыг нэгтгэн харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлсэн байна.

2.2.Паркийн удирдлага, паркийн нэгжийн үйл ажиллагаанд дараах төрлийн татварын дэмжлэг үзүүлнэ:

- 2.2.1.гаалийн албан татварын чөлөөлөлт;
- 2.2.2.үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;
- 2.2.3.газрын төлбөрийн чөлөөлөлт;
- 2.2.4.татвар төлөх хугацааны хөнгөлөлт.
- 2.2.5.татварын бусад дэмжлэг.

2.3.Паркийн удирдлага, паркийн нэгжийн үйл ажиллагаанд дараах төрлийн санхүү, төсвийн дэмжлэг үзүүлнэ:

2.3.1.үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргуулахад дэмжлэг үзүүлэх;

2.3.2.төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих;

2.3.4.улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын бонд болон холбогдох бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх;

2.4.Паркийн удирдлага, нэгжийн үйл ажиллагаанд дараах төрлийн үйл ажиллагааны дэмжлэг үзүүлнэ:

2.4.1.паркийн нутаг дэвсгэрт гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.4.2.төсөл, хөтөлбөртэй холбоотойгоор шаардлагатай зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх;

2.4.3.гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгоход дэмжлэг үзүүлэх;

2.4.4.паркийн удирдлага, нэгж үйлдвэрлэлийн ажилчдыг сургах, дадлагажуулах зорилгоор гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ үзүүлсэн бол ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх;

2.4.5.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах;

2.4.6.хуульд заасан бусад дэмжлэг.

2.5. Паркийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагууд нь холбогдох мэдээллийг харилцан солилцоно.

### **Гурав. Паркийн бүртгэл ба мэдээлэл**

3.1. Паркийн нэгж нь хуульд заасан дэмжлэг авах хүсэлтийг паркийн удирдлагаар дамжуулан гаргана.

3.2. Паркийн удирдлага нь хуульд заасан дэмжлэгт хамрагдах боломжтой паркийн нэгжүүдийн мэдээллийг нэгтгэн харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах баримт бичгийн хамт хүргүүлнэ:

3.2.1. паркийн удирдлагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;

3.2.2. паркийн удирдлагын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар;

3.2.3. хүчин төгөлдөр гэрээ байгуулсан паркийн нэгжийн жагсаалт, тэдний үйл ажиллагааны танилцуулга, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тусгасан байх;

3.2.4. паркийн нэгжийн үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалын боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамаарсан байх.

3.3. Паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.2-т заасан хүсэлт бүхий мэдээллийг хүлээн авч бүртгэн, ажлын 5 хоногт багтаан энэ журмын 2.5-т заасны дагуу дараах төрийн байгууллагуудад хүргүүлнэ:

3.3.1. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.3.2. татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

3.3.3. гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

3.3.4. харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар;

3.3.5. гадаадын иргэн, харьяатын газар;

3.3.6. хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.3.7. бусад төрийн байгууллага.

3.4. Энэ журмын 3.3-т заасан мэдээллийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2.1, 11.2.2, 11.2.3, 11.2.4, 11.2.6-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

3.5. Паркийн удирдлага нь паркийн нэгж хасагдсан, шинээр нэмэгдсэн талаарх мэдээллийг харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

3.6.Харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.5-д заасан мэдээллийг хүлээсэн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан энэ журмын 3.2-т заасан төрийн байгууллагуудад мэдээлнэ.

3.7.Энэ журмын 3.2-т заасан төрийн байгууллагууд нь паркийн талаар мэдээллийн санг үүсгэж, паркийн удирдлага, паркийн нэгжийн хүсэлт, тэдэнд үзүүлсэн дэмжлэгийн талаарх бүртгэлийг хийж, жил бүр холбогдох мэдээллийг дараа жилийн эхний сарын 20-ны дотор нэгтгэн харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.8.Паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.7-д заасан мэдээллийг хүлээн авч, нэгтгэн тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

### **Дөрөв.Татварын дэмжлэг үзүүлэх**

4.1.Татварын ерөнхий хуулийн 75.1.1, 78 дугаар зүйл болон Гаалийн тухай хуулийн 268<sup>1</sup>, 289 дүгээр зүйлд заасны дагуу татварын болон гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь татварын дэмжлэгийн талаарх хууль тогтоомжийг мэдээллийн сангаар дамжуулан нийтэд тогтмол мэдээлнэ.

4.2.Татварын болон гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь паркийн нэгж, паркийн удирдлагын энэ журмын 4.1-д заасан мэдээлэл авах эрхийг хангаж, шаардлагатай татварын дэмжлэгийг хэрхэн эдлэх асуудлаар зөвлөмжийг тухай бүр тогтмол өгнө.

4.3.Паркийн нэгж, паркийн удирдлага нь татварын дэмжлэг авах хүсэлтийг дараах журмаар гаргана:

4.3.1.тайлан гаргадаг татварын төрлийн хувьд татварын дэмжлэг авах хүсэлтийг татварын тайлан гаргах үед харьяа татварын албанд цахимаар хүсэлтийг хүргүүлнэ;

4.3.2.тайлан гаргадаггүй татварын төрлийн хувьд татвар төлөгчөөр бүртгүүлэх үед холбогдох татварын дэмжлэгийг авах хүсэлтийг харьяа татварын албанд цахимаар хүсэлтийг хүргүүлнэ.

4.4.Гаалийн байгууллага нь паркийн нэгж, паркийн удирдлагын импортолж, экспортолж буй бараа, тээврийн хэрэгслийн хувьд гаалийн бүрдүүлэлт хийх тухай бүр холбогдох татварын дэмжлэгийг үзүүлнэ.

4.5.Паркийн нэгжийн үйлдвэрлэсэн барааг лабораторийн дүгнэлтэд үндэслэн гаалийн байгууллага нь татварын дэмжлэгийг үзүүлнэ.

4.6.Паркийн удирдлага, паркийн нэгж нь дараах татварын дэмжлэг эдэлнэ:

4.6.3.Газрын төлбөрийн тухай хуулийн 8.1.9-д заасан чөлөөлөлт;

4.6.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7.3 дахь хэсэгт заасан хөнгөлөлт, чөлөөлөлт;

4.6.4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.20 гаалийн албан татварын чөлөөлөлт;

4.6.5.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.4-т заасан татвар хойшлуулах дэмжлэг;

4.7.Паркийн удирдлага, паркийн нэгж нь паркийн үйл ажиллагаанаас үл хамаарч дараах төрлийн татварын дэмжлэг эдлэх эрхтэй:

4.7.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;

4.7.2.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан чөлөөлөлт;

4.7.3.Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлд заасан татвар төлөх хугацааны хөнгөлөлт.

4.7.4.хуульд заасан бусад.

### **Тав.Санхүү, төсвийн дэмжлэг үзүүлэх**

5.1.Үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах дэмжлэгийг дараах журмаар үзүүлнэ:

5.1.1.паркийн удирдлага, паркийн нэгж нь үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хамрагдах зорилгоор төрөөс баталгаа гаргуулах хүсэлтийг харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

5.1.2.паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь паркийн удирдлагаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, судлан үндэслэлтэй гэж үзвэл холбогдох хүсэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилна;

5.1.3.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ирүүлсэн хүсэлтийг Өрийн удирдлагын тухай хуулийн 23, 26, 28<sup>1</sup>, 33 дугаар зүйлд заасан шалгуур хангасан эсэхийг тогтооно;

5.1.4.Өрийн удирдлагын тухай хуулийн 8.2.7-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээний саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ;

5.1.5.энэ журмын 5.1.4-т заасан асуудлыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, дунд хугацааны төсвийн төсөөллийн тухай хууль болон тухайн жилийн төсвийн төсөлд тусгуулан, батлуулсан байна.

5.2.Төр, хувийн хэвшлийн түншлэл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын дэмжлэгийг дараах журмаар үзүүлнэ:

5.2.1.паркийн удирдлага нь паркийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан дэд бүтэц, барилга байгууламжийн бүтээн байгуулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллагад холбогдох хүсэлтийг хүргүүлнэ;

5.2.2.паркийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага нь хүсэлтийг хүлээн авч судлан үндэслэлтэй гэж үзвэл, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

5.2.3.түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох хүсэлтийг хүлээн авч, судлан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан журмын дагуу шаардлагатай судалгааг гүйцэтгэн, төслийг түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэх шийдвэрийн төслийг гаргана;

5.2.4.түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр холбогдох төслийг түншлэлээр хэрэгжүүлэх шийдвэрийг Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ;

5.2.5.энэ журмын 5.2.4-т заасан шийдвэрт үндэслэн төсөл хэрэгжүүлэх этгээдийг сонгон шалгаруулж, холбогдох дэд бүтэц, барилга байгууламжийг барина.

5.3.Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг улс, орон нутгийн төсөв болон Засгийн газрын бондын эх үүсвэрээс санхүүжүүлэх дэмжлэгийг дараах журмаар үзүүлнэ:

5.3.1.паркийн удирдлага нь паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхэд улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын бондын эх үүсвэрээс санхүүжүүлэх хүсэлтийг харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

5.3.2.харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг судлан үндэслэлтэй гэж үзвэл, хууль тогтоомжид заасан цагалбарын дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөлд тусгуулах саналыг хүргүүлж шийдвэрлүүлнэ.

### **Зургаа.Үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх**

6.1.Паркийн нутаг дэвсгэрт гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэхэд дараах журмыг баримтална:

6.1.1.паркийн удирдлага, паркийн нэгж нь паркийн нутаг дэвсгэрт гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат үйлдвэр байгуулах хүсэлтийг харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

6.1.2. паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг судлан дараах асуудлаар дүгнэлт гарган, үндэслэлтэй гэж үзвэл хүсэлтийг гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад уламжилна:

6.1.2.1.салбарын хөгжлийг дэмжих эсэх;

6.1.2.2.дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх эсэх;  
6.1.2.3.хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх эсэх;  
6.1.2.4.улсын эдийн засагт тэргүүлэх ач холбогдол бүхий салбар, чиглэлийн үйлдвэрлэл эсэх;

6.1.2.5.тодорхой нэрийн барааны дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх эсэх.

6.1.3.гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хүсэлтийг хянахдаа дараах нөхцөл байдлыг харгалзан үзэж, гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат үйлдвэр байгуулах асуудлаар холбогдох зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг гаргана:

6.1.3.1.тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад хамрагдсан эсэх;

6.1.3.2.хяналт тавих гаалийн байгууллагын хүний нөөц, үйл ажиллагааны зардалд сөргөөр нөлөөлөх эсэх;

6.1.3.3.тухайн аж ахуйн нэгж баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхэлж байсан эсэх.

6.2.Паркийн удирдлага, паркийн нэгжийн үйл ажиллагаатай холбоотойгоор төсөл, хөтөлбөрт шаардлагатай зөвшөөрөл авахад дараах журмаар дэмжлэг үзүүлнэ:

6.2.1.паркийн удирдлага, паркийн нэгж нь паркийн үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн зөвшөөрөл авах хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээдэд шууд гаргах эрхтэй;

6.2.2.паркийн удирдлага, паркийн нэгж нь паркийн үйл ажиллагаанд шаардлагатай зөвшөөрлийн талаар тодорхойлох албан бичгийг харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргуулахаар хүсэлт хүргүүлж болно;

6.2.3.паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 6.2.2-т заасан тодорхойлолтыг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзахгүй бөгөөд уг тодорхойлолтыг ажлын 5 хоногт багтаан холбогдох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

6.3.Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох дэмжлэгийг дараах журмаар үзүүлнэ:

6.3.1.паркийн удирдлага нь гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээ, нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтад тусгуулах паркийн нэгжүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн, удирдах, гүйцэтгэх, туслах ажилтны ажлын байрны төрлөөр тоо хэмжээг ялган тодорхойлж, харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн эхний улиралд багтаан хүргүүлнэ;

6.3.2.харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 6.3.1-т заасны дагуу ирүүлсэн саналыг паркийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан тооцож, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох хууль тогтоомжид заасан хуваарийн дагуу хүргүүлнэ;

6.3.3.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь саналыг нэгтгэн Засгийн газарт хүргүүлж батлуулна.

6.4.Паркийн удирдлага, паркийн нэгжид ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх дэмжлэгийг дараах журмаар үзүүлнэ:

6.4.1.паркийн нэгж нь үйлдвэрлэлийн ажилчдыг сургах, дадлагажуулах зорилгоор гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ үзүүлэх зорилгоор ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлтийг паркийн удирдлагад хүргүүлнэ;

6.4.2.паркийн удирдлага нь энэ журмын 6.4.1-т заасан хүсэлтийг хүлээн авч, нэгтгэн харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

6.4.3.паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 6.4.2-т заасан хүсэлтийг хүлээн авч судлан, үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд холбогдох хүсэлтийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжилна;

6.4.4.хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 6.4.3-т заасан хүсэлтийг хүлээн авч, холбогдох журмын дагуу Засгийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6.5.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэхэд дараах журмыг баримтална:

6.5.1.паркийн удирдлага, паркийн нэгж нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ авах, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах эрхтэй;

6.5.2.паркийн удирдлага, паркийн нэгж нь хүсэлт гаргасан тохиолдолд харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шаардлагатай дэмжлэг хүссэн тодорхойлолтыг шийдвэр гаргах эрх бүхий этгээдэд хүргүүлж болно.

### **Долоо.Хяналт тавих**

7.1.Паркийн удирдлага, паркийн нэгж нь энэ журмын дагуу дэмжлэг авах хүсэлтэд шаардлагатай баримт бичгийг үнэн зөв, бүрэн бүрдүүлж өгнө.

7.2. Паркийн удирдлага, паркийн нэгжийн бүрдүүлж өгсөн баримт бичиг нь хуурамч, худал мэдээлэл агуулсан нь энэ журамд заасан дэмжлэгийг цуцлах, үзүүлсэн дэмжлэгийг буцаан шаардах үндэслэл болно.

7.3. Паркийн удирдлага, паркийн нэгжид дэмжлэг үзүүлсэн байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэгийн хэрэгжилтийг хянан шалгах эрхтэй.

7.4. Энэ журмын 7.3-т заасан байгууллага нь гүйцэтгэсэн хяналт шалгалтын талаарх мэдээллийг харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

7.5. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16.4-т заасан нөхцөл бий болсон тохиолдолд паркийн удирдлага нь паркийн нэгжтэй байгуулсан гэрээг цуцалж, энэ талаарх холбогдох мэдээллийг харьяалах паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.6. Паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь уг паркийн нэгжтэй холбоотой нөхцөл байдлыг дэмжлэг үзүүлсэн байгууллагуудад мэдэгдэж, дэмжлэгийг буцаан шаардах ажиллагааг эхлүүлнэ.

7.7. Паркийн нэгж нь энэ журмын 7.6-д заасан мөнгөн төлбөрийн дэмжлэгийг 30 хоногийн дотор буцаан төлнө.

---oOo---

## **ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

20.... он ... сарын .....өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### **ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ:**

Нэг талаас ..... үйлдвэрлэл технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Яам” гэх) түүнийг төлөөлж ..... албан тушаалтай .....овогтой ... .

Нөгөө талаас ..... аймаг /дүүрэг/-т паркийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан ..... регистрийн дугаартай ..... (цаашид “паркийн удирдлага” гэх) түүнийг төлөөлж.... албан тушаалтай ..... овогтой .... нар энэхүү гэрээг байгуулав.

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү гэрээний зорилго нь үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг дэмжихтэй холбоотойгоор паркийн тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Яам хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### **Хоёр.Гэрээний нөхцөл**

2.1.Энэ гэрээний хугацаа нь Үйлдвэрлэл, технологийн парк (цаашид “парк” гэх)-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаатай ижил байна.

2.2.Гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлж, хөгжлийн болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлсэн гэж үзсэн бол Засгийн газар тусгай зөвшөөрлийг 15 хүртэл жилийн хугацаагаар сунгана. Энэ тохиолдолд гэрээний хугацааг тусгай зөвшөөрлийн хугацаагаар сунгаж болно.

### **Гурав.Паркийн удирдлагын эрх, үүрэг**

3.1."Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам"-д заасан дэмжлэг авна.

3.2.Паркийн удирдлага нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан эрх, үүргийн хүрээнд паркийн дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ:

- а. ....
- б. ....
- в. ....

3.3.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2.2, 11.2.4 дахь заалт, 16 дугаар зүйл, Засгийн газраас баталсан "Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам"-д заасан нөхцөл, шаардлагыг паркийн удирдлага бүрэн хангаж ажиллана.

3.4.Паркийн удирдлага нь нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж, паркийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.

3.5.Шаардагдах дэд бүтцийг барьж байгуулах, эзэмших, түүний хэвийн үйл ажиллагааг хангана.

3.6.Гэрээний биелэлтийн тайланг жил бүрийн эцэст гэрээ байгуулсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, гэрээг дүгнэх нөхцөлөөр хангана.

3.7.Паркийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан журам, заавар, Монгол Улсын болон олон улсын стандартыг мөрдөн ажиллана.

### **Дөрөв.Яамны эрх, үүрэг**

4.1.Паркийн удирдлагаас гэрээний биелэлтийн талаар болон үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах, шаардлагатай тохиолдолд бичгээр тайлан авах эрхтэй.

4.2.Гэрээний биелэлттэй холбоотойгоор паркийн үйл ажиллагаанд шалгалт хийх зорилгоор үйлдвэрийн талбайд саадгүй нэвтэрч, холбогдох бичиг баримттай танилцах эрхтэй.

4.3.Паркийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж ажиллана.

4.4.Аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгч, зөвлөмж гаргана.

4.5.Шинэ технологи нэвтрүүлэх, мэргэжлийн үйл ажиллагааны стандарт тогтоох, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалт татах, сурталчлах чиглэлээр мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай уялдаа холбоог хангаж ажиллана.

4.6.Гэрээний биелэлтэд хяналт тавьж, жил бүрийн эцэст паркийн удирдлагатай хамтран гэрээг дүгнэнэ.

4.7.Гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байгаа паркийн удирдлагаас гэрээний үүргийн биелэлтийг шаардах болон удаа дараа шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

### **Тав.Бусад**

5.1.Гэрээний хэрэгжилтийн явцад гарч болзошгүй аливаа маргаантай асуудлыг талуудын хоорондын харилцан зөвшилцөл, тохиролцоогоор шийдвэрлэнэ.

5.2.Маргаантай асуудлыг талууд энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын шүүх эсхүл Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ.

5.3.Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5.4.Гэрээний оролцогч талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд гэрээний салшгүй хэсэг болно.

5.5.Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй байна.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үйлдвэрлэл, технологийн паркийн  
асуудал эрхэлсэн сайд

.....

(овог, нэр)

.....

(гарын үсэг)

Парк /оноосон нэрээр/-ийн  
удирдлагыг төлөөлж

.....

(албан тушаал)

...../...../

(гарын үсэг)

(овог, нэр)

## **ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН УДИРДЛАГА, ПАРКИЙН НЭГЖТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

20.... он ... сарын .....өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### **ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ:**

Нэг талаас ..... аймаг /дүүрэг/-т паркийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан ..... регистрийн дугаартай ..... (цаашид “паркийн удирдлага” гэх) түүнийг төлөөлж.... албан тушаалтай ..... овогтой .... нар энэхүү гэрээг байгуулав.

Нөгөө талаас ..... аймаг /дүүрэг/-т паркийн үйл ажиллагаа эрхлэх ..... регистрийн дугаартай ..... (цаашид “паркийн нэгж” гэх) түүнийг төлөөлж.... албан тушаалтай ..... овогтой .... нар энэхүү гэрээг байгуулав.

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд үйлдвэрлэл, технологийн парк (цаашид “парк” гэх)-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй паркийн нэгж болон паркийн удирдлагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

### **Хоёр.Гэрээний нөхцөл**

2.1.Энэхүү гэрээний хугацаа нь паркийн нэгжийн техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг хамаарч 15 хүртэл жил байх ба энэ хугацаа нь паркийн удирдлагын тусгай зөвшөөрлийн хугацаагаар хязгаарлагдана.

2.2.Паркийн нэгж нь энэ гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлж, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлсэн гэж паркийн удирдлага үзсэн тохиолдолд гэрээний хугацааг 15 хүртэл жилээр сунгаж болно.

### **Гурав.Паркийн удирдлагын эрх, үүрэг**

3.1.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2.1, 11.2.3, 11.2.4, Засгийн газраас баталсан "Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам"-д заасан нөхцөл, шаардлагыг бүрэн хангаж ажиллана.

3.2. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бусад аж ахуйн нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар хангах замаар паркийн нэгжийн хэвийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.3. Паркийн нэгжид арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллана.

3.4. Паркийн нэгжээс гэрээний биелэлтийн тайланг улирал бүрийн эхний сард багтаан хүлээн авч, дүгнэнэ.

3.5. Паркийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан журам, заавар, Монгол Улсын болон олон улсын стандартыг мөрдөн ажиллана.

3.6. Паркийн нэгжид үйлчилгээ үзүүлсний төлөө хураамж авна.

3.7. Паркийн нэгж нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.

3.8. Паркийн нэгжид газрыг гэрээний үндсэн дээр ашиглуулах.

3.9. Паркийн нэгжид хөрөнгө оруулалт татах, бүтээгдэхүүнээ борлуулах, хүний нөөцийг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээ авахад зуучлах, бусад шаардлагатай үйлчилгээ үзүүлэх.

### **Дөрөв. Паркийн нэгжийн эрх, үүрэг**

4.1. Паркийн нэгж нь дараахь үйл ажиллагааг эрхэлнэ:

- а. ....
- б. ....
- в. ....

4.2. Паркийн нэгж нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

4.3. Паркийн нэгж нь гэрээний биелэлт болон үйл ажиллагааны явцын тайланг паркийн удирдлагад энэхүү гэрээний 3.4-т заасан хугацаанд хүргүүлж, жилийн эцэст хоёр тал хамтран дүгнэнэ.

4.4. Засгийн газраас тогтоосон журам болон гэрээний дагуу холбогдох хураамжийг төлж, паркийн удирдлагаас хууль тогтоомжид заасан үйлчилгээ үзүүлэхийг шаардах эрхтэй.

4.5. Паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангуулах, холбогдох хуульд заасан дэмжлэгийг авна.

4.6. Паркийн удирдлагыг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардана.

4.7. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан мэдээллийн санд үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл өгөх, авах.

4.8. Паркийн дэд бүтцийг тэгш эрхтэй ашиглах.

4.9. Паркийн хураамжийг тогтоосон хугацаанд төлөөгүй бол журамд заасан хариуцлага хүлээнэ.

4.10. Паркийн нэгж нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16.4-т заасан нөхцөл бий болсон тохиолдолд төрөөс авсан мөнгөн дэмжлэгийг 30 хоногт багтаан буцаан төлнө.

4.11. Энэ гэрээний 4.10-т заасан төлбөрийг хугацаанд нь буцаан төлөөгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хугацаа хэтрүүлсэн хоногт тутам төлнө.

### Тав.Бусад зүйл

5.1. Гэрээний хэрэгжилтийн явцад гарч болзошгүй аливаа маргаантай асуудлыг талуудын хоорондын харилцан зөвшилцөл, эвийн журмаар шийдвэрлэнэ.

5.2. Хэрэв маргаантай асуудлыг талууд энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүх, эсхүл Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Үндэсний арбитраар шийдвэрлүүлнэ. /тохирох хувилбарыг сонгох/

5.3. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5.4. Гэрээний оролцогч талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд гэрээний салшгүй хэсэг болно.

5.5. Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд хувиуд адил хүчинтэй байна.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Паркийн удирдлагыг төлөөлж:

Паркийн нэгжийг төлөөлж:

.....

(албан тушаал)

.....

(албан тушаал)

...../...../

(гарын үсэг)

(овог, нэр)

...../...../

(гарын үсэг)

(овог, нэр)

-----oOo-----